

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛООР ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

*/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/*

2020.07.22

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан”-г 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн ХЭГ/1503 тоот албан бичгээр Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлсэн.

“Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тайланд шинжилгээ хийж, Байнгын хорооны эрхлэх асуудал тус бүрээр ялган гаргасан болно. Шинжилгээний дүнд үндэслэн бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн хэсэг, заалтыг хяналтаас хасах саналыг хавсаргав.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ХЭСЭГ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Монгол Улсын хуулиар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн 105 хуулийн 527 хэсэг, заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс хяналтад авч, мэдээллийн санд бүртгэсэн болно.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 99 хуулийн 427 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 99 хуулийн 426 хэсэг, заалт буюу 80.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 12 /давхардсан тоогоор/ хуулийн 101 хэсэг, заалт буюу 19.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Харин өмнөх онуудад хяналтаас хасагдсан 1 хуулийн 1 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль /давхардсан тоогоор/	Хэсэг, заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	105	527
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	99	427
	- Хяналтад байгаа	99	426
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	1	1

3	Засгийн газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	12	101
---	---	----	-----

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 99 хуулийн 427 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 67 хуулийн 250 хэсэг, заалт буюу 58.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 28 хуулийн 54 хэсэг, заалт буюу 12.6 хувь нь хэрэгжих шатанд, 18 хуулийн 36 хэсэг, заалт буюу 8.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 23 хуулийн 29 хэсэг, заалт буюу 6.8 хувь нь хэрэгжээгүй, 25 хуулийн 58 хэсэг, заалт буюу 13.6 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 10 хуулийн 67 хэсэг, заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны 10 хуулийн 63 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 1 хуулийн 4 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 10 хуулийн 63 хэсэг, заалтаас давхардсан тоогоор 8 хуулийн 36 хэсэг, заалт буюу 57.1 хувь нь бүрэн хэрэгжсэн, 6 хуулийн 11 хэсэг, заалт буюу 17.5 хувь нь хэрэгжих шатанд, 5 хуулийн 13 заалт буюу 20.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 хуулийн 3 заалт буюу 4.8 хувь нь хэрэгжээгүй байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт	
	Тоо	Тоо	Хувь	
Хяналтад авсан	10	67	100.0	
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	10	63	94.02	
Үүнээс:				
- бүрэн хэрэгжсэн	8	36	57.1	
- хэрэгжих шатанд	6	11	17.5	
- хэрэгжилт хангалтгүй	5	13	20.6	
- хэрэгжээгүй	2	3	4.8	

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Тариалангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8-д заасан “Энэ хуулийн 15.7-д заасан газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлалыг тариалангийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”, Хог хаягдлын тухай хуулийн 8.5.1-т заасан “8.5. Хог хаягдлын талаар батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.5.1. харьяа нэгж, байгууллагад үүссэн болон цэргийн зориулалтаар ашиглаж байсан газарт үлдсэн галт зэвсэг, сум, галт хэрэглэл, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис, тэдгээрийн үлдэгдлийг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн заалтуудын хэрэгжилт 2019 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжих шатанд буюу 70 хувийн хэрэгжилттэй байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй

болж хэрэгжилтийн хувь буурсан байна.

Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т заасан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, энэ хуулийн 7.2-т заасан тайланг үндэслэн малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиглах, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг Засгийн газар батална. /7.2.Энэ хуулийн 7.1-д заасан шинжээчийн баг малын генетик нөөцийн төлөв байдлын тайланг Үндэсний зөвлөлдөх хороогоор хэлэлцүүлж, гарсан дүгнэлтийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилийн гуравдугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.” гэсэн заалтын хэрэгжилтийг “Малын генетик нөөцийн төлөв байдлын тайланд үндэслэн 2020 оны 04 дүгээр улиралд багтаан малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, ашиглах, хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн” гэж тайлагнаад “хэрэгжээгүй” гэж үнэлж ирүүлсэн байна.

2019 оны эхний хагас жилтэй харьцуулахад 2019 оны жилийн эцсийн байдлаар 4 хуулийн 33 хэсэг, заалт шинээр нэмэгдэж ирсэн байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт:

№	БОХХААБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн хуулийн нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй хуулийн хэсэг, заалт
1	Хог хаягдлын тухай тухай /Шинэчилсэн найруулга 2017.05.12/	16.9; 31.1; 32.1; 34.4 дэх хэсэг, заалт
Нийт 1 хуулийн 4 хэсэг, заалт		

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 238 заалтыг хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 55 тогтоолын 171 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс хяналтад байгаа 38 тогтоолын 118 заалт буюу 49.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, давхардсан тоогоор 40 тогтоолын 120 заалт буюу 50.4 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 24 тогтоолын 53 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтанд авсан	70	238
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	55	171
	- Хяналтад байгаа	38	118
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	24	53

3	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	40	120
---	---	----	-----

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн Улсын Их Хурлын 38 тогтоолын 118 заалтаас давхардсан тоогоор 30 тогтоолын 74 заалт буюу 62.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11 тогтоолын 31 заалт буюу 26.3 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 9 заалт буюу 7.6 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.9 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 2.5 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 8 тогтоолын 19 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын 7 тогтоолын 18 заалт буюу 94.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 1 тогтоолын 1 заалт буюу 5.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 7 тогтоолын 18 заалтаас давхардсан тоогоор 4 тогтоолын 10 заалт буюу 55.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 тогтоолын 4 заалт буюу 22.2 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 4 заалт буюу 22.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	8	19	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	7	18	94.7
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	4	10	55.5
- <i>Хэрэгжих шатанд</i>	3	4	22.2
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	3	4	22.2

3.3. Мэдээнд гарсан зөрчил

Малчид үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2012 оны 74 дүгээр тогтоолын 2.5-т заасан "арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулах.", Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай 2015 оны 81 дүгээр тогтоолын 2-т заасан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасгай.", Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018 оны 30 дугаар тогтоолын 1.1-т заасан "Хууль хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт болон хуульд заасан захиргааны хэм хэмжээний актыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний дотор батлах.", 1.2-т заасан "Хүнсний албан журмаар

баяжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, баяжуулагч бэлдмэлийн импортыг дэмжих, үйлдвэрлэл эрхлэгч нарт дэмжлэг үзүүлэх боломжит арга замыг судалж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний дотор танилцуулах.” гэсэн заалтуудын хэрэгжилтийг 30 буюу хэрэгжилт хангалтгүй гэж үнэлж ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээ нь үнэлгээнээс зөрүүтэй байх, хэрэгжилтийн тайланг дутуу тайлагнах зөрчил байна. Тухайлбал, Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2018.05.03 №30/ Улсын Их Хурлын тогтоолын “Хууль хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт болон хуульд заасан захиргааны хэм хэмжээний актыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний дотор батлах.” гэсэн заалтын хэрэгжилтийг тайлагнахдаа “Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтыг ЗГ-ын 2018 оны 336 дугаар тогтоолоор батлуулсан.” гээд хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувь гэж үнэлж ирүүлсэн.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй Улсын Их Хурлын тогтоолын заалт:

№	БОХХААБХ-ны эрхлэх асуудлын хүрээн дэх Улсын Их Хурлын тогтоолын нэр	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй тогтоолын заалт
1	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай /2019.12.06 №100/	1 дэх заалт
Нийт 1 тогтоолын 1 заалт		

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООДЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

4.1. Байнгын хороодын тогтоолын хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтэс 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хороодоос Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн нийт 99 тогтоолын 673 заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 82 тогтоолын 420 заалт буюу 62.4 хувийн хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн нь бүгд хяналтанд байх заалтууд байна. Давхардсан тоогоор 47 тогтоолын 253 заалт буюу 37.6 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

		Тогтоол /давхардсан тоогоор/	Заалт
1	2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан	99	673
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн Үүнээс:	82	420
	- Хяналтад байгаа	82	420
	- Хяналтаас хасагдсан заалтыг дахин ирүүлсэн	-	-
3	ЗГХЭГ-аас 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	47	253

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 82 тогтоолын 420 заалтаас давхардсан тоогоор 65 тогтоолын 252 заалт буюу 60.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 47 тогтоолын 100 заалт буюу 23.8 хувь нь хэрэгжих шатанд, 20 тогтоолын 26 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 11 тогтоолын 28 заалт буюу 6.7 хувь нь хэрэгжээгүй, 12 тогтоолын 14 заалт буюу 3.3 хувь нь үнэлэх боломжгүй гэсэн мэдээ ирүүлсэн байна.

4.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 15 тогтоолын 70 заалтыг Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналтад байгаа тус Байнгын хорооны 14 тогтоолын 65 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 3 тогтоолын 5 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	БОХХААБХ-ны тогтоол	Заалт	
	/давхардсан тоогоор/	Тоо	Хувь
<i>Хяналтад авсан</i>	15	70	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	14	65	92.8
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	11	36	55.4
- <i>Хэрэгжих шатанд</i>	8	19	29.2
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	6	9	13.8
- <i>Үнэлэх боломжгүй</i>	1	1	1.5

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 14 тогтоолын 65 заалтаас давхардсан тоогоор 11 тогтоолын 36 заалт буюу 55.4 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 тогтоолын 19 заалт буюу 29.2 хувь нь хэрэгжих шатанд, 6 тогтоолын 9 заалт буюу 13.8 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 1.5 хувь нь үнэлэх боломжгүй байна.

4.3. Мэдээнд гарсан зөрчил

Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй Байнгын хорооны тогтоол, хуралдааны тэмдэглэлийн заалт:

№	БОХХААБХ-ны тогтоолын нэр, хуралдааны тэмдэглэл огноо, дугаар	Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй Байнгын хорооны тогтоолын болон хуралдааны тэмдэглэлийн заалт
1	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний тухай /2012.12.06 №05/	1; 2; 1 дэх заалт
2	Чиглэл өгөх тухай /2016.01.22 №01/	1.2 дахь заалт
3	Засгийн газарт чиглэл өгөх тухай /ӨБХ-той хамтарсан, 2019.05.28 №04/01/	1.3 дахь заалт
Нийт 3 тогтоолын 5 заалт		

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2019 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн буюу 100 хувь гэж үнэлэн ирүүлсэн Монгол Улсын 8 хуулийн 36 хэсэг, заалтыг хасах санал ирүүлснээс 3 хуулийн 5 заалтыг хяналтад үлдээхээр, Улсын Их

Хурлын 4 тогтоолын 10 заалтыг хасах санал ирүүлснээс 2 тогтоолын 3 заалтыг хяналтад үлдээхээр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 11 тогтоолын 36 заалтыг хяналтаас хасах санал ирүүлснээс 9 тогтоолын 16 заалтыг хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэн хяналтад үлдээж, хасах саналтай бусад заалтуудыг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, тус Байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах 1 хуулийн 4 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 1 тогтоолын 1 заалт, Байнгын хорооны 3 тогтоолын 5 заалтын хэрэгжилтийн мэдээг бүрэн ирүүлээгүй болно.
2. Хэрэгжилтийн мэдээ нь үнэлгээнээс зөрүүтэй байх, хэрэгжилтийн тайланг дутуу тайлагнах зөрчил гарч байна.
3. 2019 оны эхний хагас жилийн мэдээтэй харьцуулахад хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувийг бууруулж үнэлэх, хяналтанд авсан зарим заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй орхигдуулах зэрэг зөрчил гарч байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ИЙН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1	Усны тухай /шинэчилсэн найруулга/ 2012.05.17	10.1.10. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлах	Байгаль орчин, аялал жуулчлалын яам: Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журмын төслийг шинэчлэн боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/301/265 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.
		24.7. Энэ хуулийн 24.2-т заасан хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийн загварыг байгаль орчны болон хот, суурины усан хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	БОАЖ-ын болон БХБ-ын сайдын 2019.11.22-ны өдрийн А/719/189 дугаар хамтарсан тушаалаар “Хаягдал ус зайлуулах зөвшөөрлийн бичгийн загвар”-ыг батлуулсан.
2	Ус бохирдуулсны төлбөрийн тухай 2012.05.17	4.5. Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журмыг энэ хуулийн 7.1-д заасныг үндэслэн Засгийн газар тогтооно.	Улсын Их Хурал 2019.05.02-ны өдөр Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэ хуульд нийцүүлэн Засгийн газар "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох, журам"-ыг 2019.08.14-ний өдрийн 316 дугаар тогтоолоор баталсан.
		6.2. Хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг үйлдвэр, үйлчилгээний салбар бүрээр усны хэрэглээний норм, хүчин чадал, ашиглалтын горимыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.	Хоногт 50 шоометрээс бага, аюултай бохирдуулах бодис агуулаагүй хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай журмын төслийг боловсруулж, БОАЖ-ын сайд, БХБ-ын Сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/816/218 дугаар тушаалаар батлуулав.
3	Хүнсний тухай /шинэчилсэн найруулга/ 2012.12.20	16.2. Энэ хуулийн 16.1-д заасан баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах	“Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 515 дугаар тушаалаар батлуулж, баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг эхлүүлсэн. Одоогоор 20 гаруй нэр төрлийн баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт,

		журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	өсгөврийн хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэж, дугаараа авсан.
4	Тариалангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2016.01.29	19.6.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмын төслийг боловсруулан сангийн яаманд хүргүүлж хамтран ажилласнаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2019 оны 290/А-504 дүгээр хамтарсан тушаалаар урамшууллын журмын батлаж энэ оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
		21.4. Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг эцэслэн боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-43 дугаар тушаалаар батлуулан Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлэн нийтээр даган мөрдөж байна.
5	Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017.05.12	7.1. Хог хаягдлын талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7.1.1. хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах;	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолоор баталсан. Үндэсний хөтөлбөр хэрэгжиж буй тул хяналтаас хасах саналтай байна.
		7.1.4. Монгол Улсад импортлохыг хязгаарласан болон хориглосон зарим хог хаягдлын жагсаалт батлах;	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн “Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодолсон жагсаалтад нэмэлт оруулах тухай” 199 дүгээр тогтоолыг батлуулсан.
		8.1.14. Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” А/429-257 дугаар тушаалын хавсралтаар “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт”-ыг батлуулан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4048 дугаарт бүртгүүлсэн.
		8.3.3. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлсийг тооцох аргачлалыг батлах;	Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлсийг тооцох аргачлалыг батлуулахын тулд эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын хэмжээ, ангилал зэргийг нарийвчлан судалж, хортой болон ахуйн хог хаягдлын эзлэх хувь зэрэг нарийвчлан тооцоолж, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Аргачлал, норматив хэмжээ батлах тухай” А/605 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлсийг тооцох аргачлал”-ыг баталсан.
		8.3.4. Энэ хуулийн 8.1.10-т заасан аргачлалын дагуу эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын норматив хэмжээг тогтоох;	БОАЖЯ-аас энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлалыг 2018 оны сүүлээр баталсан бөгөөд энэхүү аргачлалд тулгуурлан эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын норматив хэмжээг шинэчлэн боловсруулахаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж МХЕГ, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, НЭМГ, ХӨСҮТ, ХСҮТ, УНТЭ, УХТЭ, НЭМҮТ, ЭМСХХ-4, 5 төслийн НТХН, Элемент ХХК-д санал авч, нэгтгэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Аргачлал, норматив хэмжээ батлах тухай”

			A/605 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын норматив хэмжээ”-г баталсан.
6	Мал, амьтны эрүүл мэндийн тухай 2017.12.08	7.9. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэлийг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 43 дугаар тогтоолоор “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам” батлагдсан.
		11.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт оношлогдсон мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалтыг доор дурдсан ангиллаар Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 225 дугаар тогтоолоор “Монгол Улсын нутаг дэвсгэрт оношлогдсон мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт”-ыг 3 ангиллаар баталснаар, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
		12.3. Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хяналтад авах төлөвлөгөө, халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 2 сарын 20-ны өдрийн А-40 дүгээр тушаалаар “Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хяналтад авах төлөвлөгөө, халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам” батлагдсан.
		17.1. Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална	Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолоор “Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг баталсан тул нийтээр дагаж мөрдөж байна.
		17.2.4. Халдварт өвчний тархалт төмөр зам, олон улсын нисэх буудал, хилийн боомт, хилээр дамжин өнгөрүүлэх цэгийг хамарсан, эсхүл хоёр буюу түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэр дэх голомтыг нэгтгэх нөхцөл үүссэн бол мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар.	Мал эмнэлгийн ерөнхий газар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба 17.2.4-т заасан тохиолдол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлснээр, тухайн нөхцөл үүсээгүй байна.
		18.2. Хязгаарлалтын дэглэм тогтоох өвчний жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 2 сарын 12-ны өдрийн А-34 дугаар тушаалаар “Хязгаарлалтын дэглэм тогтоох өвчний жагсаалт” батлагдсан.

	<p>23.2. Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд байгуулж, ажиллах журмыг хамтран батална.</p>	<p>ХХААХҮ-ийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А-449, А/541 дүгээр хамтарсан тушаалаар Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, ажиллах журмыг батлан, хууль эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн</p>
	<p>25.2. Мал, амьтны тэжээлийн нэмэлтийг бүртгэх, худалдах, эгүүлэн татах, импортын зөвшөөрөл олгох журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А-456 тоот тушаалаар “Мал, амьтны тэжээлийн нэмэлтийг бүртгэх, худалдах, эгүүлэн татах, импортын зөвшөөрөл олгох журам” батлагдсан.</p>
	<p>26.1. Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд дэх эм, пестицидийн үлдэгдлийн хяналтын үндэсний хөтөлбөрийг Засгийн газарт танилцуулж, мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А-178 дугаар тушаалаар “Малын эмийн үлдэгдлийн хяналт”-ын үндэсний хөтөлбөр батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
	<p>27.14. Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 10 сарын 25-ны өдрийн А-181 дүгээр тушаалаар "Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам" батлагдаж, нийтээр мөрдөн ажиллаж байна.</p>
	<p>28.1. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 186 дугаар тогтоолоор МЭЕГ, 188 дугаар тогтоолоор УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18 өдрийн А/174 тоот тушаалаар аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар, сумдын мал эмнэлгийн тасаг байгуулагдан ажиллаж байна.</p>

	<p>28.3. Энэ хуулийн 28.2-т заасан байгууллага харьяандаа мал эмнэлгийн судалгаа, шинжилгээ, оношилгоо, эрүүл ахуй, ариун цэвэр, сорилт, баталгаажуулалтын лаборатори ажиллуулж болно.</p> <p>/28.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангах, хүн амыг зооноз өвчний эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавина./</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 188 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяанд “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газар, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулан ажиллаж байна.</p>
	<p>28.4. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал эмнэлгийн салбарын бүх шатны байгууллага, лаборатори, мал эмнэлгийн тасаг болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.</p>	<p>ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18 өдрийн А/174 тоот тушаалаар аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын бүтэц орон тоог баталсан. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/45 тоот тушаалаар “Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн бүтэц, орон тоог, 2018 оны А/26 дугаар тушаалаар “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” ТӨҮГ-ийн бүтэц орон тоог баталж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.</p>
	<p>28.5. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, худалдааны чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай үйл ажиллагаагаа уялдуулж хамтран ажиллана.</p>	<p>Мал эмнэлгийн ерөнхий газар нь Мал эмнэлгийн хүрээлэнтэй гэрээ байгуулан, хамтран ажиллаж Монгол улс үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг баталгаажуулах ажлыг хийж байна. ХААИС-ийн Мал эмнэлгийн сургуультай ажил гүйцэтгэх 3 гэрээг байгуулан хамтран ажиллаж, мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчний судалгааг хийлгэж байна.</p> <p>УМЭАЦТЛ, Биокомбинат УТҮГ, МЭЭСБУЛ УТҮГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, сэргилэх арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Зөвлөх малын эмч нарын холбоо ТББ, Хувийн мал эмнэлгүүдийн дундын хоршоо ТББ-тай хамтран ажиллаж мал эмнэлгийн үйлчилгээ, журам, заавар зэргийг хамтран болосвруулж, бодлого, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж байна</p>
	<p>28.7.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг Засгийн газар:</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 193 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байна.</p>
	<p>28.11. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд мал, амьтны эмийн</p>	<p>Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдсантай холбогдуулан ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А-14 дүгээр тушаалаар Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журам батлагдсан. Мал эмнэлгийн</p>

		бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хянах үүрэг бүхий орон тооны бус малын эмийн салбар зөвлөл, фармакопейн хороо ажиллана.	ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/18 дугаар тушаалаар Мал эмнэлгийн малын эмийн салбар зөвлөлийг 12, фармакопейн хороог 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж байна.
		28.13. Малын эмийн салбар зөвлөл болон фармакопейн хорооны ажиллах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А-14 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар “Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг, 2 дугаар хавсралтаар “Фармакопейн хорооны ажиллах журам”-ыг тус батлуулж, мөрдөж байна.
		30.18. Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/457 дугаар тушаалаар “Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам”-ыг баталж, нийтээр мөрдөн ажиллаж байна.
7	Баяжуулсан хүнсний тухай 2018.05.03	5.2. Энэ хуулийн 5.1-д заасан саналыг үндэслэн албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтыг Засгийн газар батална. /5.1. Хүнсний тухай хуулийн 9.1.1-д заасан судалгааны дүнг үндэслэн эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран албан журмаар баяжуулах хүнсний талаархи саналыг Засгийн газарт хүргүүлнэ./	Монгол Улсын Их Хурлаас Баяжуулсан хүнсний тухай хуулийг 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр баталсан. Энэ хуулийн хүрээнд “Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт”-ыг Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 336 дугаар тогтоолоор баталж, энэ жагсаалтын дагуу буудайн гурил болон давсыг баяжуулахаар шийдвэрлэсэн. Хүн амын дунд түгээмэл дуталтай эрдэс, амин дэмийн төрөл болон үйлдвэрлэлийн технологийн явцад үүсэх алдагдлыг тус тус тооцсоны үндсэн дээр давсыг иоджуулах, харин буудайн гурилыг В бүлгийн болон Д амин дэм, төмөр, цайр агуулсан холимог найрлагатай бэлдмэлээр баяжуулахаар ажиллаж байна.
Нийт 7 хуулийн 31 хэсэг, заалт.			

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	Ногоон хөгжлийн бодлого батлах тухай 2014.06.13 №43	2.1. “Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж эхлэх;	“Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн Газрын 2016 оны 35 дугаар тогтоолоор баталсан.
2	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль/ 2017.12.08 №81	1.1 Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: Хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын болон шилжилтийн үеийн бэлтгэл ажлыг хангах. 1.3. Холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.	Хуулийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор дараах Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан батлуулав. Үүнд. 1.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол /2018 оны 05 сарын 30 өдрийн 41 дүгээр тогтоол/ 2.“Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоол /2018 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн 186 дугаар тогтоол/ 3.“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоол /2018 оны 8 дугаар сарын 22-ний өдрийн 267 дугаар тогтоол/ 4.“Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоол /2018 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн 188 дугаар тогтоол/ Дээрх тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газрын бүтэц, орон тоог ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Агентлагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай” А-115 дугаар тушаалаар, Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, сум, мал бүхий дүүргийн Мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн хяналтын цэгийн бүтэц, орон тоог ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн “Бүтэц, орон тоог батлах тухай” А-174 дугаар тушаалаар тус тус батлуулан, зохион байгуулсан. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2018 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн нэгдсэн чуулганаар дараах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, батлуулсан. 1.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 3.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 4.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 5.Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
3	Хууль	1.2. Хууль хэрэгжүүлэхтэй	Хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалт, шилжилтийн үеийн бэлтгэл ажлыг хангах

	<p>хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /Малын генетик нөөцийн тухай хууль/ 2017.12.14 №82</p>	<p>холбогдсон зохион байгуулалт, шилжилтийн үеийн бэлтгэл ажлыг хангах;</p> <p>1.4. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.</p>	<p>чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А-07 дугаар тушаалаар ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн.</p> <p>Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сард Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон Малын генетик нөөцийн тухай хуулиудыг батлуулах үед Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж, хамтад нь өргөн мэдүүлсэн боловч тухайн үед Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өргөн мэдүүлэх үндэслэлээр хэлэлцээгүй хойшлуулсан болно.</p> <p>Иймд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, болон бусад багц хуулийн төсөлд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах зохицуулалтыг тусгуулахаар хүргүүлсэн. Эдгээр багц хуулийн төслийг Хууль зүйн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцсон. Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлагдахад холбогдох хуулиудын өөрчлөн найруулга тусч батлагдсан.</p>
4	<p>Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018.01.05 №02</p>	<p>1.1. Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай.</p> <p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмж, Монгол Улсын Их Хурлын агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2016 оны 01 дүгээр, 2017 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд 2018 оны 02 дугаар сарын 01-ний дотор танилцуулах;</p>	<p>Тогтоол, шийдвэрийн дагуу 2018.01.22-нд Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулахад авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээний тухай мэдээллийг УИХ-д танилцуулсан.</p>

		<p>1.2. Нийслэл болон төвлөрсөн суурин газрын агаарын бохирдлыг бууруулах, утааг багасгах асуудлыг тухайлан хариуцах төрийн захиргааны бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, шаардлагатай тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан байгууллага байгуулах эсэх асуудлыг судалж, шийдвэрлэх, агаар орчныг бохирдуулж байгаа асуудалд хариуцлагын тогтолцоог цогц тодорхой тусгасан шинэ хуулийн төсөл, холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хууль, тогтоолын төслийг 2017 оны намрын чуулганы хугацаанд боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох шаардлагагүй гэж үзэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/645 дугаар тушаалаар Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Ажлын албыг шинэчлэн байгуулан үйл ажиллагаа жигдрэн ажиллаж байна.</p> <p>МХЕГ-ын даргын 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/32, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн Б/143 дугаар тушаалаар 14 хүний бүрэлдэхүүнтэй Агаарын чанарын хяналтын хэлтэс байгуулагдан ажиллаж байна.</p> <p>Нийслэлд зөвшөөрснөөс бусад хэрэгцээнд түүхий нүүрсний хэрэглээг хязгаарласан. Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд агаар бохирдуулагч эх үүсвэр ашиглагч 5365 иргэн аж ахуйн нэгж, байгууллага, шахмал түлшний 8 үйлдвэр, ахуйн зуух худалдан борлуулахыг хориглосон 3 зах, худалдааны төвүүд, Налайх дүүрэгт нүүрс олборлогч 54 иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж 148.5 сая төгрөгийн торгууль тавьж, зөрчлийг арилгуулах талаар улсын байцаагчийн 2190 албан шаардлага, мэдэгдэл хүргүүлж биелэлтийг тооцож ажиллаа. Хяналт шалгалтын үр дүнд 1080 объектын янданг буулгуулж цахилгаанд халаагуурт шилжүүлж, шаардлага хангахгүй, агаарын чанарын бүсийн дэглэм зөрчсөн 1561 объектын зуухыг буулгах, зогсоох, сайжруулсан зуухаар солих арга хэмжээ авч ажилласан.</p> <p>Орчны бохирдлын бууруулах үндэсний хорооноос үүрэг болгосны дагуу 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Нийслэл хотын төвийн 6 дүүрэгт эрчим хүч, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагаас бусад гэр хороололд амьдарч байгаа айл өрх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийг түүхий нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан жилийн 4 улиралд маршрутын бус замд байнгын хяналт тавихаар Ар гүнтийн даваа, Налайхын зам дагуу, Морингийн даваа, Тахилтын даваанд явуулын хяналтын цэгүүдийг ажиллуулж байна.</p> <p>Дээрх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн ажилласны үр дүнд 2019 оны 10-11 дүгээр сарыг 2018 оны мөн үетэй харьцуулахад PM2.5 буюу нарийн ширхэгт тоосонцор 42 хувиар буурсан, PM10 буюу том ширхэгт тоосонцрын хэмжээ 55 хувиар буурсан үзүүлэлт гарсан байна.</p>
Нийт 4 тогтоолын 7 заалт.			

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛ /ХЭСЭГ, ЗААЛТ/-ЫН ЖАГСААЛТ
/2019 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2010.11.12 №07	1.8. “Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн, ач холбогдлыг аймаг, сум, багийн түвшинд өргөнөөр сурталчлах ажлыг оновчтой зохион байгуулах.	Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар жил бүрийн 1 дүгээр сард “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ХХААХҮ-н яаманд ирүүлснийг нэгтгэн үнэлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан тайлагнадаг. Монгол мал хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө 80,0-87,2 хувийн биелэлттэй гарч байна. Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлтэд яам, Засгийн газар үнэлсэн үнэлгээг хүргүүлж, биелэлт хангалтгүй байгаа үйл ажиллагааг хэрхэн сайжруулах, орон нутгийн төсөвт санхүүжилтийг тусгах шаардлагатай байгаа зөвлөмжийг хүргүүлдэг. Аймаг, нийслэлийн ХХААГазар нь яамнаас хүргүүлсэн Монгол мал хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг бүх сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасагт хүргүүлж, сум, баг, малчдын түвшинд сурталчлах ажлыг зохион байгуулах чиглэл өгсний дагуу орон нутагт сурталчлан ажиллаж байна.
2	Монгол орны ойн цэвэрлэгээний талаар авах арга хэмжээний тухай 2014.01.15 №04	1.3. Ойн цэвэрлэгээнээс гарсан мод, модон бүтээгдэхүүн борлуулах, үртэс зоргодсоор шахмал түлш, барилгын материал үйлдвэрлэх санаачилгыг дэмжин зохион байгуулж, хэрэгжилтийг хангах талаар аймаг, нийслэлийн засаг дарга нарт үүрэг, чиглэл өгч ажиллах;	Одоо 21 аймаг, нийслэлд 450 гаруй аж ахуй нэгж байгууллага /+200 гаруй ХЭАА/, мод бэлтгэл, ойн цэвэрлэгээ, мод боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 5,0 мянга орчим ажиллагсадтайгаар боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний 2-3 %-ийг үйлдвэрлэж байна. Статистик мэдээгээр сүүлийн 3 жилд жил бүр 14-18 тэрбум төгрөгийн, албан бус мэдээгээр 100 -110 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. -Үйлдвэрлэлийн чиглэл: Мод бэлтгэл, зүсмэл материал, модон бэлдэц, мебель тавилга, зөөлөн тавилга, модон байшин, барилгын модон хийц, гэрийн мод, хөгжмийн зэмсэг, модон тоглоом, бэлэг дурсгал, шахмал түлш - Мод, модон материал, тавилгын 45 орчим хувийг дотооддоо 55 орчим хувийг импортоор авч байна. Барилгын дотор хаалга, гал тогооны тавилгын 50-60 %-ийг дотоодын үйлдвэрүүд үйлдвэрлэж байгаа ба 100 % дотооддоо үйлдвэрлэх боломж бүдээд байна. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд "Мегаүүд" ХХК-д экспортыг дэмжих 7,6 тэрбум төгрөгийн зээл олгосноор тус компанийн ойн хаягдал, унанги ашиглан төрөл бүрийн хавтангийн цогцолбор үйлдвэрийн 10000 м2 талбайтай үйлдвэрийн барилга ашиглалтад 2019 оны 11 дүгээр сард орсон. - Инжир" ХХК-ний хэрэгжүүлж буй угсармал модон хавтангийн Дарханы цогцолбор үйлдвэрийн 1-р ээлжийн хөрөнгө оруулалтыг Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлд хамруулсан. Тус үйлдвэрийн 2-р ээлжийн хөрөнгө оруулалтын төслийг Монгол-Хятадын экспо-3-д төрийн зүгээс танилцуулж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийхээр шийдвэрлэсэн.

3	Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх, ойн нөхөн сэргээлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2014.04.29 №07	1.2. Ойн сан бүхий газарт ой нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, нөхөрлөлийн хаягдал ашиглан эко бетон үйлдвэрлэх жижиг үйлдвэр байгуулах санаачлагыг дэмжих, жижиг дунд үйлдвэрийн сан, зээлийн баталгааны сангаас дэмжлэг үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;	Мод боловсруулах үйлдвэрийг Хөвсгөл аймгийн тэргүүлэх чиглэлийн үйлдвэрүүдэд оруулан эрэмбэлсэн. Тус асуудлын хүрээнд “Ойн төгөл” ХХК-ийн шахмал хавтангийн төсөлийг ЖДҮХС-гаас санхүүжүүлэн 50 сая төгрөгийн зээл олгоод байна. - Сэлэнгэ аймгийн хэмжээнд жилд 11365 м3 палк 40 тн шахмал түлш, 144 ш гэрийн мод үйлдвэрлэх хүчин чадалтай нийт 25-н үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж байна. - Мод боловсруулах чиглэлийн 7 төслийг сум хөгжүүлэх сангаас дэмжиж, 46,5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. - Хэнтий аймгийн аймгийн ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлд мод, модон бүтээгдэхүүний чиглэлийн төсөлд 45,0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон
4	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны тогтоол Чиглэл өгөх тухай 2017.02.08 №01	1.2. Шинээр баригдах цахилгаан түгээх сүлжээний дэд станцуудын газрын асуудлыг шийдвэрлэх; 1.3. “Агаарын бохирдлын эсрэг сан”-г байгуулахаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, агаарын бохирдлын төлбөрийг зориулалтын дагуу зарцуулах; 1.4 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын шинэ санал, санаачилгыг дэмжиж ажиллах. 2. Энэ тогтоолоор өгсөн чиглэлийн биелэлтийг Дэд хороонд 2017-2018 оны намрын чуулганы хугацаанд танилцуулсугай.	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах ажлын хүрээнд Шинээр баригдсан 246 дэд станцын газрын асуудлыг шийдвэрлэсэн Мөн Чингэлтэй дүүрэгт байрлах Самбалхүндэв хэмээх чимээгүй хотын 1000 гаруй шарилыг нүүлгэн шилжүүлж 110/10кВт-ын хүчин чадалтай “Хүчит шонхор дэд станц”-ийг шинээр барьж байгуулав. Агаарын бохирдлын төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулах зорилготой “Агаарын бохирдлын эсрэг сан” байгуулахаар Агаарын тухай хууль болон бусад дагалдах хуулийн төслийг 2018.01.12-ны өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан. 2019 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зарим санг бие даасан сан байх шаардлагагүй гэж үзэн Агаарын бохирдлын эсрэг санг татан буулгаж, Байгаль орчин, уур амьсгалын сантай нэгтгэсэн. 2019 оны 09 дүгээр сарын 15-аас 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын бүх хороодод “Гэр байшингаа хэрхэн дулаалах, ногоон зээлд хамрагдах боломж, сайжруулсан шахмал түлш хэрэглэх дараалал, анхаарах асуудал зэрэг мэдээлэл агуулсан 160 мянган ширхэг гарын авлага бэлтгэн гэр хорооллын айл өрхүүдэд хорооны хэсгийн ахлагч нараар дамжуулан хүргэсэн. ОББҮХ, агаар орчны бохирдлын талаар баримталж буй бодлого түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар 20-40 секундийн 20 ширхэг шторк бэлтгэн 7 фм радиоогоор дамжуулан иргэдэд мэдээлсэн. Сайжруулсан түлшээр галлах зааварчилгаа бэлтгэн БОАЖЯ, ОББҮХ-ны цахим хуудас, Эзэнтэй мэдээ, Утаа улс төр биш пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Сайжруулсан түлшийг хэрэглэж буй бодит нөхцөл байдлыг газар дээр нь сурвалжилж, түлшийг галлахад анхаарах асуудал, түлшийг хэрхэн зөв хэрэглэх заавар зэргийг иргэдэд хүргэсэн. ОББҮХ “Утааны эсрэг ээж аавууд” ТББ, Монголын байгаль орчны иргэний зөвлөлтэй хамтран иргэдэд гэр байшингаа хэрхэн дулаалах, сайжруулсан шахмал түлшийг хэрхэн зөв хэрэглэх талаар сургалт хийсэн. УИХ-ын 2017.11.10-ны өдрийн хуралд БОАЖСайд 2017 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай сонсгол хийсэн. - Засгийн газрын 2017.11.29-ны өдрийн хуралд Агаарын бохирдлын өнөөгийн нөхцөл байдал сэдвээр мэдээлэл хийсэн. - УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны 12 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар 2017 онд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулгыг хийсэн.

5	<p>Байгаль орчны төлөв байдлын 2015-2016 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2017.05.16 №05</p>	<p>1.1. Байгаль орчны төлөв байдлын урт хугацааны өөрчлөлтийн байдалд дүн шинжилгээ хийж, үндэсний хэмжээний хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад салбар дундын уялдаа холбоог хангах.</p>	<p>Байгаль орчны төлөв байдлын урт хугацааны өөрчлөлтийг УИХ-д өргөн барьсан урт хугацааны бодлогын баримт бичиг болох “Алсын хараа 2050”-ын Ногоон хөгжил хэсэгт, “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, “Үндэсний болон Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр” зэрэгт тус тус тусгасан.</p>
		<p>1.2. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах цөлжилттэй тэмцэх, ойн санг нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, усны менежментийг сайжруулахад шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусгах.</p>	<p>Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах цөлжилттэй тэмцэх, ойн санг нэмэгдүүлэх, биологийн төрөл зүйлийг хамгаалах, усны менежментийг сайжруулахад шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусган төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>
		<p>1.5. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр гарсан хууль, хууль тогтоомжийн бусад шийдвэрийг иргэд, аж ахуйн нэгжид сурталчлах, хэрэгжилтийг хангах.</p>	<p>Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн боловсролын чиглэлээр http://ncle.edu.mn/esd/ мэдээллийн сан, байгаль орчинд ээлтэй, цэвэр технологийн мэдээллийн сан /https://eic.mn/greentech-г 2016 оноос эхлэн хөтөлж, нийт 272 технологийг бүртгээд байна олон нийтэд сурталчилан ажиллаж байна.</p> <p>2019 онд салбарын хууль тогтоомж, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх мэдлэг мэдээллийг олон нийтэд хүргэх, тогтвортой амьдралын хэв маягийг хэвшүүлэх чиглэлээр дараах ном, гарын авлагыг хэвлүүлж олон нийтэд түгээсэн. Үүнд: салбарын бодлого, үндэсний хөтөлбөрийн эмхтгэл /300ш/, “Тогтвортой хөгжлийн боловсрол” үндэсний хөтөлбөрийн эмхтгэл /500ш/, Хөвсгөл аймгийн Ногоон хөгжлийн бодлогод суурилсан тогтвортой хөгжлийн мастер төлөвлөгөө, 2018-2028, /300ш/, 2016-2017 онд тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр мэргэшсэн сэтгүүл зүйн салбарын сургагч багш нартай хамтран “CHANGE” буюу “Өөрчлөлтийн жимээр” сэтгүүлийн анхны хэвлэл /100ш/ зэрэг болно.</p> <p>Албан боловсролын хүрээнд: Байгаль орчныг хамгаалах, экологийн боловсрол хүмүүжил олгох зорилгоор “Улсын биологийн 29 дугаар олимпиад”, “Экологийн 17 дугаар олимпиад”, “Микробиологийн оюутны олимпиад”-ыг МУИС-тай хамтран 2019 онд зохион байгуулав. Байгаль хамгаалах үйлсэд хүүхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх, ёс заншлаа дээдэлсэн, байгальд ээлтэй зөв дадлыг төлөвшүүлэх, өсвөрийн байгаль хамгаалагчдыг бэлтгэх зорилгоор “Ногоон паспорт” аяныг БОАЖЯ-аас санаачлан хэрэгжүүлж байна. Тус аянд одоогийн байдлаар 543 сургуулийн дунд, ахлах ангийн 62,500 гаруй сурагчдыг хамруулаад байна. 2019 онд “Ногоон паспорт” эзэмшигч сурагчдын байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр 18 удаагийн сургалтад нийт 4964 сурагчдыг хамруулж чадавхжуулсан байна. “Ногоон Паспорт” аяны хүрээнд “Сургуулийн орчиндоо мод тарьцгаая-2019” үйл ажиллагааг хамтран зохион байгуулж 10,000 нарс модны суулгацыг ерөнхий боловсролын 100 сургуульд үнэ төлбөргүй өгч сурагчид болон багш, эцэг эхчүүдийг “Бүх нийтээр мод тарих өдөр”-т идэвхтэй оролцоход уриалж, амжилттай хамруулсан. Аяны хүрээнд “Хог түүх марафон” уралдааныг зохион байгуулж, нийслэлийн шилдэг эко клуб, багш,</p>

			<p>сурагчдыг урамшуулан шагнасан. Идэвхтэй ажилладаг клубын тоо 103-д хүрсэн байна. Албан бус боловсролын хүрээнд: БОАЖЯ, Азийн сантай хамтран “Хог хаягдал ба жендэр” сэдэвт сургалт, семинарыг оролцогч талууд болох төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн 30 орчим төлөөллийг хамруулан зохион байгуулсан. “Манлайлах урлаг ба жендэрийн мэдрэмж” 2 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.</p> <p>2016-2019 оны хооронд Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14000 багцын стандартыг орчуулж батлуулах ажлын хүрээнд нийт 10 стандарт батлуулсан. ААНБ-уудад ISO 14000 стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотод 2 удаа /2018.09.11-14, 2018.10.08-11/, Дорноговь /2018.08.09-12/, Өмнөговь /2018.09.25-28/ аймгуудад тус бүр нэг удаа Байгаль орчны менежментийн тогтолцооны стандарт хэрэгжүүлэгч бэлтгэх сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. Сургалтад нийт 274 хүн хамрагдсанаас 84 ААНБ-ын 87 хүнд хэрэгжүүлэгчийн сертификат олгосон. 2019 оны 5-р сард Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх сургалтыг 50 аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг оролцуулан хийсэн. 2019 онд Еврохан ХХК, Хаанзаа сервис ХХК, Альянс минерал ХХК, АПУ ХК, Энержи ресурс ХХК, MCS проперти ХХК, Эко ноос ХХК, Цэцүүх ХХК, Агь ХХК, Дархан-Уул аймгийн АШУҮИС-ийн салбар Анагаах ухааны сургууль зэрэг байгууллагууд ISO 14001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж баталгаажуулсан.</p>
		2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан БОХХААБХ-д танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад үүрэг болгосугай.	Байгаль орчны төлөв байдлын тайланг 2 жил тутам нэгтгэн товхимол болгон хэвлүүлэн БОХХААБХ-д танилцуулж хэвшсэн.
6	Агаарын бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай /БОХХААБХ/ НББСШУБХ/ 2018.05.30 №07/16	1.1. Тогтоолын заалтуудыг хэрэгжүүлэх хугацаа, хариуцах эзэн, хөрөнгийн эх үүсвэр, хүрэх үр дүнг заасан нэгдсэн төлөвлөгөөг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор баталж, хэрэгжүүлэх;	Тогтоолын хэрэгжилтийг хангахаар 2017.03.20 ҮАБЗ-ийн зөвлөмжийг үндэслэн Ерөнхий сайдын 51 дүгээр захирамжаар Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо болж шинэчлэгдэн зохион байгуулагдсан бөгөөд 2019 онд БОАЖ-ын сайдын 2019 оны А/222, А/734 дугаар тушаалаар Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албаны орон тоо, бүтцийг шинэчлэн зохион байгуулж байнгын ажиллагаатай бүтцийг бий болгосон. Тус хорооны тогтоолоор жил бүр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах хөрөнгийг батлан хэрэгжүүлж үйл ажиллагаа тогтмолжсон.
		1.3. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил, арга хэмжээг нэгдсэн байдлаар уялдааг ханган шийдвэрлэж, ажлыг эрчимжүүлэх;	2017.03.20 ҮАБЗ-ийн зөвлөмжийг үндэслэн Ерөнхий сайдын 51 дүгээр захирамжаар Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо болж шинэчлэгдэн зохион байгуулагдсан бөгөөд 2019 онд БОАЖ-ын сайдын 2019 оны А/222, А/734 дугаар тушаалаар Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажлын албаны орон тоо, бүтцийг шинэчлэн зохион байгуулж байнгын ажиллагаатай бүтцийг бий болгосон. Мөн үндэсний хорооны дэргэд Зөвлөлдөх эрдэмтдийн баг ажиллуулах ажлын удирдамж батлагдсан. Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтэд 4600 сайн дурын орон тооны бус ажилчид, Нийслэлийн мэргэжлийн хяналтын Агаарын чанарын хяналтын хэлтэст явуулын 4 пост байгуулж, 24 гэрээт ажилтан, Цагдаагийн Ерөнхий газарт “Эргүүл хяналт шалгалтын нэгж” байгуулагдаж, 58 албан хаагчидтай бие бүрэлдэхүүн, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын 128 хүний бүрэлдхүүнтэй хяналт, шалгалтын баг тус бүр түүхий нүүрсний хяналт,

		галлагаа, аюулгүй байдал, үнс зэрэгт хяналт тавин мэдээлэл түгээж байгаа ба энэ ажлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар хамтран ажиллаж хэвшсэн.
	1.4. Агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 2018, 2019 онд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгож, нэн даруй хэрэгжүүлэх;	2019 онд агаарын бохирдлыг бууруулах чиглээр 75.2 тэрбум төгрөгийг хуулийн дагуу нийт 32 арга хэмжээнд зарцуулсан бол 2020 онд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд 53.0 тэрбум төгрөг зарцуулан сайжруулсан түлш үйлдвэрлэх хүчин чадлыг 600.0 мянган тонноор нэмэгдүүлэх, цахилгаан эрчим хүчний хэрэглээг дэмжих, нийтийн тээврийн агаарт ялгарах бохирдлыг багасгах, аймгуудын агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, аймгуудын дулааны эх үүсвэрт утаа шүүх шүүлтүүр тавих зэрэг арга хэмжээг; хөрс, усны бохирдлыг бууруулах арга хэмжээнд 8.0 тэрбум төгрөг зарцуулан гэр хорооллын нүхэн жорлонг өөрчлөн сайжруулах, төв цэвэрлэх байгууламжаас гарах бохирдлыг бууруулах; хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд 10.0 тэрбум төгрөг зарцуулан хог хаягдлыг дахин боловсруулах болон аймаг орон нутгийн хог хаягдлыг бууруулах; агаар, орчны бохирдлыг бууруулах инновац, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, мониторингийн сүлжээг сайжруулах, мэдээлэл сурталчилгааг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч үр дүнтэй ажиллаж байна.
	1.5. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Байгаль орчин, аялал, жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хандсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой санал, санаачлага, төсөл, арга хэмжээг судлан үзэж, үр ашигтай төсөл, арга хэмжээг салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор сонгож, улс, орон нутгийн төсөв, хөнгөлөлттэй зээлийн хэмжээнд багтаан саналыг нэгтгэх;	2019 онд жилд 600 мянган тонн сайжруулсан шахмал түлш үйлвэрлэх, гэр хорооллын айл өрхүүдийг угаарын хий /CO/-н хордолтоос сэргийлэх мэдрэгчээр хангах, улсын төсөвт 36 байгууллагын халаалтыг цахилгаан, байгалийн хий, газрын гүний дулааны халаалтад шилжүүлэх, 101 кВт-аас дээш хүчин чадалтай 220 усан халаалтын зуухны янданд усан шүүлтүүр суурилуулах, байгалийн шатдаг хийгээр ажилладаг 70 автобус нийлүүлэх, 24 дизель хөдөлгүүртэй автобусны хөө тортгийг 90% бууруулах шүүлтүүр тавих, том оврын 400 автобусанд бохирдлыг бууруулах төхөөрөмж суурилах, гэр хорооллын иргэдэд цахилгаан халаагуур, байшин, сууцны дулаалга, эко жорлонгоо шийдэхэд нь дэмжлэг болох зорилгоор иргэдэд жилийн 9 хүртэл хувийн хүүтэй 40 хүртэл сая төгрөгийн ногоон зээлийг Төрийн банк, Хаан банк, Хас банкнуудтай хамтран олгох, зээлийн хүүгийн татаасанд дэмжлэг үзүүлэх, 4 төрлийн агаар цэвэршүүлэгч, 10 төрлийн эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх, агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ыг урамшуулж ногоон гэрчилгээ олгох, "Агаар, орчны бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе", "Гэр байшингаа дулаалъя, сайжруулсан шахмал түлш хэрэглэе, ногоон зээлд хамрагдаж агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэе", Одонтой ээжүүд агаарын бохирдлын эсрэг хүчээ нэгтгэж байна", "Хандлагаа өөрчлөө", "Хоггүй цэвэрхэн Монгол" зэрэг уриалгуудыг олон нийтэд хүргэх зэрэг ажлуудыг хөтөлбөрийн 1-р үе шатанд амжилттай хэрэгжүүлсний үр дүнд 2019 онд Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 19-38%-иар, PM10 тоосонцор 3-43%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

		1.6. Тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа асуудалд дүгнэлт хийж, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох, тогтоол, ажлын хэсгийн зөвлөмжүүдийн хүрээнд хийгдэж буй ажлын тайланг сар бүрийн эхний долоо хоногт танилцуулж байх.	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж хэвшсэн.
7	Чиглэл өгөх тухай 2018.11.02 №08	1.8. Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, дэлхийн жишигт нийцсэн мал үржүүлэг, орчин үеийн биотехнологийн шинжлэх ухааны ололт, дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх;	Малын удмын сангийн үндэсний төвд хөврөл үр, үр үйлдвэрлэлж, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөхүйц сүүлийн үеийн технологиор хөлдөөх, хадгалах зориулалт бүхий тусгай зохиулалтын лабораторийн бүрэн автомажсан тоног төхөөрөмжийг нийт 799,9 сая төгрөгөөр худалдан авч суурилуулан 2019 оны 1 дүгээр сараас 2020 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд нийт 10,0 мянган тун үрийг технологийн дагуу авч, хөлдөөж генийн санд хадгалав. Малын удмын сангийн үндэсний төвийн судалгаа, үйлдвэрлэлийн ажилд биотехнологийн ололт, молекул, генетикийн шинжлэх ухааны аргуудыг нэвтрүүлэх зорилгоор 2018 онд нийт 568,9 сая төгрөгөөр орчин үеийн багаж, тоног төхөөрөмж худалдан авч Молекул, генетикийн лабораторийг байгуулан ажиллагаанд оруулан Хөдөө аж ахуйн их сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран холбогдох мэргэжилтнийг мэргэшүүлэн сургаж байна. Япон улсын генетикийн нөөцийн судалгааны байгууллага болох “Сецеротек” ХХК-тай 2020 онд хамтран ажиллах Санамж бичиг байгуулан Баянхонгор аймгийн Залаа жинстийн цагаан ямаанд генийн жолоодлого хийж ноолуурын гарц чанарыг сайжруулах, хөврөл үр шилжүүлэн суулгах чиглэлээр туршилт, судалгааны ажлыг хийхээр бэлтгэл зохион байгуулалтын ажлыг хийж байна. Малын удмын сангийн үндэсний төвийн захиралын 2020 оны А-04 дүгээр тушаалаар “Малын генетик нөөц ашиглат-20000” бүтээлч ажлын аян зарлан томоохон аж ахуйн нэгжүүдийн гадаад орнуудаас импортоор авсан хээлтүүлэгч малаас үр авч орчин үеийн технологиор хөлдөөж хадгалах ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж байна.
		1.10. Орон нутгаас тухайн жилд шаардлагатай таримал тэжээлийн захиалгыг авчны үндсэн дээр тариалалт хийх, шаардагдах стандартыг боловсруулж батлуулах;	Тухайн жилд шаардагдах тэжээлийн хэрэгцээг тооцож аймгийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж байна. 2020 онд 38.2 мянган га-д малын тэжээл тариалж 76.6 мянган тонн тэжээлийн ургамал хураан авахаар төлөвлөж хэрэгжилтийг зохион байгуулж байна. 2019 оны 12 дугаар сард Ногоон тэжээлийн стандартыг боловсруулж батлуулав.
		1.12. Сэлэнгэ аймгийн ургацын 50 хувийг бүрдүүлдэг Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Зэлтэр сумдыг холбосон 120 км замыг хатуу хучилттай болгоход шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг олж шийдвэрлэх арга	Тус чиглэлийн авто замын төслийн концессын гэрээг Хөрөнгө оруулалтын газраас 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдөр “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-тай байгуулаад байсан. Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн “Концессоор хэрэгжүүлэх авто замын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 84 дүгээр тогтоолын 7 дахь заалтаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах, концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 226 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн “Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн

	<p>хэмжээ авах.</p>	<p>120.85 км хатуу хучилттай авто замын төсөл” гэснийг, хассан. Концесс эзэмшигч нь концессын гэрээг бүхэлд нь цуцалж байгаа нь буруу гэж шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 128/ШШ2018/0794 дүгээр шийдвэрийг гарган, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Үндэсний хөгжлийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 01/253 дугаартай "Концессын гэрээ цуцлах мэдэгдэл хүргүүлэх тухай" мэдэгдлийг хүчингүй болгосон. Шүүхийн шийдвэрийн үндэслэн Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн "Концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 239 дүгээр тогтоолоор "Дархан-Алтанбулагийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн ашиглалтад оруулах хугацааг 2021 он байхаар концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд зөвшөөрсний дагуу концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Концесс эзэмшигчийн зүгээс гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийг бүрэн хангасан бөгөөд Үндэсний хөгжлийн газраас тухайн төслийн ажилд техник технологийн хяналт гүйцэтгэх зөвлөхөөр “Эм Си Пи Си жи ар” ХХК, “Хязгааргүй хөдөлгөөн” ХХК-ийн түншлэлийг сонгон гэрээ байгуулсан тул зам барилгын ажлыг эхлүүлэх боломж бүрдээд байна. Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, гэрээ байгуулагдсан, зам барилгын ажлыг эхлүүлэх боломж бүрдсэн.</p>
	<p>2.Тогтоолын биелэлтийг зохион байгуулж, дүнг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд 2019 оны II улиралд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай:</p>	<p>Тогтоолын биелэлтийг УИХ-ын БОХХААБХ-д танилцуулсан.</p>
<p align="center">Нийт 7 тогтоолын 20 заалт.</p>		

Танилцуулга бэлтгэсэн: ХШҮХ-ийн референт

Б.Энхмаа